

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ДААТГАЛ					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хөрөнгийн даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Гийм <input type="checkbox"/> Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Балсан		Баярмагнай			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>							
9	Даатгалын зүйл	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай суурилуулдаг болон суурилуулдаггүй тоног төхөөрөмж					
	Даатгалын үндсэн эрсдэл	<ul style="list-style-type: none"> <li>- Гал;</li> <li>- Тэсрэлт, дэлбэрэлт;</li> <li>- Шатамхай хийнээс үүдэн гарах хохирол;</li> <li>- Байгалийн эрсдэл /аянга цахилгаан, хүчтэй цасан болон шороон шуурга гэх мэт/;</li> <li>- Сантехникийн эрсдэл, ус тосны шугам хоолой хагарах, гэмтэх, техникийн осол аваар</li> <li>- Барилгын нуралт</li> <li>- Цахилгааны гэмтэл, эрчим хүчний нөлөөлөл; хэвийн бус хэлбэлзэл</li> <li>- Тээврийн хэрэгслийн нөлөөлөл, осол аваараас үүдэн гарах хохирол /мөргөх, шүргэх/</li> <li>- Гуравдагч этгээдийн санамсаргүй болон санаатай үйлдлээс учрах эрсдэл</li> <li>- Хулгай</li> </ul>					
	Даатгалын нэмэлт эрсдэл	<ul style="list-style-type: none"> <li>- Гал унтраах зардал /800,000₮ хүртэл/</li> <li>- Үнэлгээний зардал</li> <li>- Хог хаягдлыг зайлуулах /500,000₮ хүртэл/</li> <li>- Мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, шинжээчийн ажиллагаа, үнэлгээний зардал /250,000₮ хүртэл/</li> </ul>					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	Тухайн хөрөнгийн зориулалт, төрөл, шинж чанар, хийц, материал зэрэг эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлсээс хамааран 0.2 %- 3.0 %					

## ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

Бид доорх тохиолдолд нөхөн төлбөр олгохоос татгалзана. Үүнд:

1. Даатгалын тухай хуулийн 8.5-д заасан үндэслэл бүрдсэн;
2. Урьдчилан таамаглаагүй бизнесийн саатал, ашгийн алдагдал, үр дагавраас үүдэн гарах хохирол, санхүүгийн алдагдал
3. Жижиг хулгай, битүүлгээр алга болох /ямар нэг баримт нотолгоогүй/
4. Дангаар хийгдсэн бизнесийн тасалдлын даатгал. Эд хөрөнгийн даатгалын үнэлгээний 20%-д хамаарах ба 14 хоногийн эхний доод хэмжээний өөрийн хүлээх хариуцлагатай цуг бичигдсэн бизнес тасалдал байна. Бизнес тасалдлын даатгалын хураамж хөрөнгийн даатгалын хураамжаас багагүй байна.
5. Гэрээнд нэмэлтээр тусгаагүй бол хөрөнгийн тээвэрлэгдэж байх үеийн эрсдэл, ачаа тээврийн даатгалын холбогдох хохирол;
6. Зураг, уран зураг, урлагийн эртний бүтээл, хөгжмийн зэмсэг, цуглуулга. файл, программ, бэлэн мөнгө, марк, үнэт цаас, чек гэх мэт зүйлд учрах хохирол
7. Эд хөрөнгийн ердийн элэгдэл, бараа материалын хэвийн хорогдол, зэврэлт, исэлдэл ууршилт, алдаатай эх сурвалж, далд дефект, үйлдвэрийн гэмтэл зэрэг тухайн хөрөнгө, бараа материалын шинж чанараас шалтгаалан гарсан хохирол, гэмтэл, газар хөдлөлт
8. Даатгуулагч гал, эрчим хүч, ус, дулаан, цахилгаан, сантехник ашиглалт, аюулгүй ажиллагааны хууль тогтоомж, ашиглах дүрэм, заавар, стандарт зөрчсөнөөс үүссэн хохирол,
9. Үйлдвэрлэлийн дефектгүй холбоотой үйл ажиллагааны болон ур хийцийн алдаа, алдаатай зураг төсөл, зөвшөөрөлгүй шинэчлэн боловсруулсан барилгын зураг төсөл;
10. Хөрөнгийн тооллого, бараа материалын бүртгэлийн үед гарах дутагдал, хорогдол;
11. Хөрөнгийн даатгалтай холбоогүй эрсдэл, даатгалын тохиолдол мөн эсэх нь нотлогдоогүй буюу нотлогдох боломжгүй болсон тохиолдол;
12. Шалгаагүй ба баталгаажуулаагүй технологи ашигласан, шалган турших, судалгаа, шинжилгээний ажлын явцад учирсан хохирол;
13. Даатгалын зүйлийн баталгаат хугацааны аливаа эвдрэл гэмтэл, хохирол;
14. Авто тээврийн хэрэгсэл, түүний хариуцлагын даатгал
15. Хүний үйл ажиллагаанаас хамааралтай хөрсний нуралт, цөмрөлт
16. Дайн, зэвсэгт бослого, дотоодын үймээн самуун, террорист үйл ажиллагаа, ажил хаялт, нийгмийн эмх замбараагүй байдал, бослого, төрийн захиргааны байгууллагын акт шийдвэр зэргийн улмаас үүссэн нөхцөл байдал, улс төрийн тэмцэлд оролцсоноос үүссэн;
17. Байлдааны зэвсэг хэрэглэх, цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхт бодис буюу туяаны хордлого мөн асбестос бодис ашигласнаас учирсан хохирол;
18. Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл;